



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/398

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ-Идэр сумын “Шивэрт”, “Таруугийн бэл”-ийн авто зам эвдэрч, замын хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэл үүссэн тул тус авто замд засвар, арчлалт хийх 10,000,000 (арван сая) төгрөгийн зардлыг аймгийн Замын сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2.Дээрх сумын авто замын засвар арчлалт хийх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Шинэ-Идэр сумын Засаг дарга (М.Бат-Эрдэнэ)-д, арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д тус тус даалгасугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ